*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралт*

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА Р.ГАНТУЯАГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас | | |
| **ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРТ, ДУНД, БОГИНО ХУГАЦААНЫ БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТИЙН НЭГДСЭН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ** | | | | | | | |
| 1. | *ЗГҮАХХАХТ 2.3.1.3.398* Хорт хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөр, хэрэгжүүлэх | Батлагдсан төлөвлөгөө, 2025 онд үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | Хөтөлбөрийн төсөл | Хорт хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөрийн төслийг батлуулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн байна. | Хорт хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөрийн 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт 70% | “Хорт хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөр” -ийн төслийг боловсруулж Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, гишүүдээс гарсан саналыг тусган, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/241 дүгээр тушаалаар батлагдсан. Тус хөтөлбөрт 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд дараах үйл ажиллагааг хийж байгаа.<br>• Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд зорилтот бүлгийн даатгуулагчийг хамруулах , төлбөрийг нь санхүүжүүлэх журам", Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд зоритот бүлгийн даатгуулагчийг хамруулах товлол, давтамж болорн зардлын төлбөрийн хэмжээ"-г боловсруулж ЭМДҮЗ-ийн 2025 оны 10 дугаар тогтоолоор батлуулсан.<br>• Нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт зорилтот бүлгийн хүн амыг хамруулах үйл ажиллагаа зохион байгуулах журам болон товлол, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | давтамж, эрт илрүүлгийн зураглалд хавдрын чиглэлийг боловсруулж ЭМС-ын 2025 оны А/04 дүгээр тушаалаар батлагсан.<br>• Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/351 дугаар тушаалаар "Ходоод, улаан хоолой, бүдүүн-шулуун гэдэсний хорт хавдар", 2024 оны А/352 дугаар тушаалаар "Уушгины хорт хавдар", 2024 оны А/353 дугаар тушаалаар "Хөхний хорт хавдар", А/354 дугаар тушаалаар "Элэгний хорт хавдар", А/355 дугаар тушаалаар "Умайн хүзүүний хорт хавдар"-ын дэд ажлын хэсгүүдийг тус тус байгуулагдаж зонхилон тохиолдох байрлалын оношилгоо, эмчилгээний зааврыг боловсруулж байна.<br>• Эрүүл мэндийн сайдын 2015 оны А/351 дүгээр "Хавдрын эсрэг авах зарим арга хэмжээний тухай" тушаалыг шинэчлэн боловсруулж байна.<br>• Хавдрын хяналтын тогтолцоог бүрэн цахимжуулах үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангах хүрээнд Баянгол дүүргийн 24 дүгээр хорооны ӨЭМТ, Эрүүл мэндийн төв, Хавдар судлалын үндэсний төвийг хамруулж хавдраар оношлогдсон иргэдийг зохих шатлалд нь хянах туршилтын загварыг хэрэгжүүлж байна.<br>• Улаанбаатар хотын Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад цахим системийн сургалтыг зохион байгуулж, хавдрын өвчний хяналтын цахим системийг бэлэн болголоо.<br>• Хавдрын цогц шинэчлэл" Үндэсний зөвлөгөөнийг 2025 оны 06 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан.<br>• Хавдрын үндсэн мэргэжлийн сургалтын индексийг шинэчилж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Хавдрын тусламж, үйлчилгээний ачаалал хүлээгдлийг бууруулах зорилгоор хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны үр дүнд амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин, туяа эмчилгээний хүлээгдэл 1-3 хоног болсон үр дүнтэй байна. | |
| 2. | *ЗГҮАХХАХТ 2.3.1.2.392* Эрүүл насжилтыг дэмжих арга хэмжээний төлөвлөгөө 2025-2028 батлуулах | Батлагдсан төлөвлөгөө, 2025 онд үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | Төлөвлөгөөний төсөл | Эрүүл насжилтыг дэмжих арга хэмжээний төлөвлөгөөний төслийг УЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн байна. | Эрүүл насжилтыг дэмжих арга хэмжээний төлөвлөгөөг ГБХНХС, ЭМС-ын хамтарсан тушаалаар батлуулсан байна. | "Эрүүл настан, идэвхитэй насжилтыг дэмжих" 2025-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж ГБХНХЯ- аас албан бичгээр, 2025 оны 03 дугаар сарын 20-оос 04 дугаар сарын 20-ны өдрүүдэд ЭМЯ -ны цахим хуудсанд санал авч ирсэн саналыг тусган ЭМЯ-ны удирдлагуудаас санал авч батлагдах шатандаа байна. | 70 |
| 3. | *ЗГҮАХХАХТ 2.3.2.5* Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх цогц арга хэмжээний (2025-2028) төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах | Батлагдсан төлөвлөгөө, 2025 онд үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх цогц арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж, УЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан байна. | Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх цогц арга хэмжээний төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлж батлуулж, 2025 оны хэрэгжилтийг хангасан байна. | Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх цогц арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулсан. | 50 |
| 4. | *ЗГҮАХХАХТ 2.3.1.1 МУТЖҮЧ 2.2.2* Хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг зохион байгуулах | Эрт илрүүлэг үзлэг үзлэгийн хамрагдалтын хувь | - | Эрт илрүүлгийн эрхзүйн орчныг бүрдүүлэх, зохион байгуулалтыг нэгдсэн удирдлагаар хангахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулсан байна. | Хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 16 хувьд хүрсэн байна. | Зонхилох байрлалын буюу элэг, ходоод, улаан хоолой, бүдүүн-шулуун гэдэс, уушги, хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэг, оношилгоог үндэсний хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд баг тус бүр 1 удаа, дэд ажлын хэсгүүд хамтран 6 удаа, нийт 12 удаа танхимаар хуралдаж, эрт илрүүлэг зохион байгуулах алгоритм, шаардлагатай тоног төхөөрөмж, хүний нөөц, эдийн засгийн судалгаа гаргасан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Энэ ажлын хүрээнд ЭМС-ын 2025 оны 04 дүгээр тушаал, ЭМДҮЗ-ийн 2025 оны 10 дугаар "Журам, төлбөрийн хэмжээ батлах тухай" тогтоолоор "Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд зорилтот бүлгийн даатгуулагчийг хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журам", "Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд зорилтот бүлгийн даатгуулагчийг хамруулах товлол, давтамж болон зардлын төлбөрийн хэмжээ" тус тус батлагдаж, эрх зүйн орчин бүрдсэн. Одоогийн байдлаар нийслэлийн хэмжээнд эрт илрүүлэг, оношилгоо хийх сургалтыг зохион байгуулсан ба орон нутагт сургалт зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна. Мөн цахим хөгжүүлэлтийг хийж, ХУД-ийн 1, 7 дугаар хороонд туршиж эхлээд байна. | |
| 5. | *МУХТЖҮЧ 2.2.2*<br>*ЗГҮАХ 2.3.1.1.*<br>*МУХТ 3.1.1.1*<br>"Элэг бүтэн Монгол" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Тухайн оны төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 30 | - | Тухайн оны төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангасан байна | | 0 |
| 6. | Нярайн цогц эрт илрүүлгийг үндэсний түвшинд нэвтрүүлж, хэрэгжилтийг хангах | Эрт илрүүлэг үзлэг үзлэгийн хамрагдалтын хувь | 16<br>(2023 он) | Эрт илрүүлгийн эрхзүйн орчныг бүрдүүлэх, зохион байгуулалтыг нэгдсэн удирдлагаар хангахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулсан байна. | Нярайн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 40 хувьд хүрсэн байна. | Нярайн цогц илрүүлгийг үндэсний хэмжээнд зохион байгуулах талаар эмнэлзүйн зааврыг боловсруулсан.<br>2025 оны эхний хагас жилийн байдлаар нярайн цогц эрт илрүүлгийн түнхний үзлэгт 6093, сонсголын илрүүлэгт 2081, нүдний илрүүлэгт 4501, зүрхний үзлэгт 2164, бодисынг солилцооны эмгэгийн илрүүлэгт 2906, зулайн ЭХО-д 1449 нярайг тус тус хамруулсан байна. Нярайн эрт илрүүлэгт нийслэлийн амаржих газрууд ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-II, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аймгуудаас БОЭТ-үүдэд бүрэн хийгдэж байна. | |
| 7. | Эх баригчийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028 оны) батлуулна. | Батлагдсан төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт | Төлөвлөгөөний төсөл | Төлөвлөгөөг боловсруулж, УЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан байна. | Төлөвлөгөөнд туссан 2025 оны арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | "Эх баригчийн хөгжлийн стратеги төлөвлөгөө" боловсруулах уулзалт, хэлэлцүүлгийг нийт 5 удаа зохион байгуулж 200 гаруй мэргэжилтнээр хэлэлцүүлсэн. Тухайлбал; 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгууулж, эх барих, эмэгтэйчүүдийн эмч, эх баригчдын төлөөлөл болох 25 хүнийг оролцуулан SWOT дүн шинжилгээний аргачлалаар эхний төслийн хүрээ, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон.<br>Олон улсын эх баригчдын өдөрт зориулсан "Эх баригч хүмүүнлэгийн элч" зөвлөгөөнд оролцсон 300 эх баригч нарт "Эх баригчийн хөгжлийн стратеги төлөвлөгөө 2028-2028"-ын төслийг танилцуулж, бүлгээр ажиллуулан санал авсан ба гарсан саналыг нэгтгэн шинэчлэн боловсруулсан.<br>Төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсгийг Монголын эх баригчийн нийгэмлэг, МЭБЭЭНХ, НҮБХАС-гийн техникийн мэргэжилтнүүдийн төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж, 2 удаагийн уулзалтаар төслийг шинэчлэн боловсруулсан. Ажлын хэсгийн уулзалтаар "Эх баригчийн хөгжлийн стратеги" баримт бичгийн нэрийг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, уг хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын тогтоол, Эрүүл мэндийн сайдын тушаал, шийдвэрийг үндэслэн "Эх баригчийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)" гэж өөрчлөхөөр шийдвэрлэж, төлөвлөгөөний төсөлд дээрх зөвлөгөөнд оролцогчдоос өгсөн саналуудыг тусган боловсруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Нийслэлийн Өргөө амаржих газрын эмнэлзүйн сургалтын өрөөнд ЭМЯ, НҮБХАС, АШУҮИС-ийн АУС болон Сувилахуйн сургуулийн Эх барих, эмэгтэйчүүд судлалын тэнхим, ЭМЯ-ны Эх барих, эмэгтэйчүүд судлалын Мэргэжлийн салбар зөвлөл, МЭБЭЭНХ, МЭБН, НӨАГ-ын удирдах ажилтан, мэргэжилтэн, эх барих, эмэгтэйчүүдийн эмч, багш, эх баригч нарын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж энэхүү төлөвлөгөөний төсөл, шалгуур үзүүлэлтийн төслийг танилцуулж, санал солилцсон. Хэлэлцүүлгээс гарсан саналуудыг тусган ажлын хэсэг дахин боловсруулалт хийж, дараах зорилт, үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд төлөвлөгөөний төслийг шинэчлэн боловсруулсан.<br>“Эх баригчийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2025-2028”-ний төслийг батлуулахаар ЭМЯ-ны 8 газрын 6 газраас санал аваад байна. | |
| 8. | *ЗГҮАХ 2.1.1.9.181*<br>“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний 2025-2028 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангах | Батлагдсан төлөвлөгөө | 2021 оны 760 дугаар тушаал | Төлөвлөгөөний төсөлд үнэлгээ хийгдэж, ажлын хэсгийн болон Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна. | Төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлж, санал авах үйл ажиллагааг зохион байгуулж батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын өдрийн А/465 тушаалаар “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний 2025-2028 оны төлөвлөгөө боловсхуулах ажлын хэсэг хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан ажиллаж, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/219 дүгээр тушаалаар батлагдсан. | 100 |
| 9. | *ЗГҮАХ 2.1.1.14.187*<br>"Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан | | “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ыг эмнэлгийн | Түрүү булчирхайн үрэвсэл, хортой хавдар, төмсөгний дутмагшлын үеийн азооспереми, бөөрний чулууны оношилгоо, эмчилгээний зааврыг боловсруулж, батлуулсан байна. | Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ыг эмнэлгийн мэргэжилтнүүдэд сурталчлах, ажлыг зохион байгуулах хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж, үр дүн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэргэжилтнүүдэд сурталчлах, ажлыг зохион байгуулсан байна. | | тайлан мэдээллийг Батлан хамгаалахын сайдад 1а/3001 албан бичгээр хүргүүлсэн.<br>• Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт 5/654 албан бичгээр жил бүр зохион байгуулагддаг цэрэг татлагаар эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдсөн иргэдийн тоо нэмэгдэх хандлагатай байгаад анхаарч орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх 4 чиглэлийг хүргүүлж, тайлан мэдээллийг авч нэгтгэсэн.<br>• Нийтийн эрүүл мэндийн газарт 37 дугаар дотоод меморандумаар цэргийн насны иргэдийн эрүүл мэндийн байдлыг судлах, хянах, үнэлэх эрэлт хэрэгцээнд үндэслэн нийгмийн эрүүл мэндийн бодлогыг тодорхолж ажиллах саналыг хүргүүлсэн.<br>• Батлан хамгаалах яамнаас зохион байгуулсан “Цэрэг татлага 2023” улсын зөвлөгөөнд “Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдал, цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгт анхаарах асуудал” сэдвээр илтгэл бэлтгэн танилцуулж оролцсон.<br>2025 оны 05 дугаар сарын 01-ны өдөр “Цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх үйла жиллагаанд анхаарах нь” сэдэвт цахим хурлыг аймаг, нийслэлийн эрүүлм эндийн байгууллага, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Мэргэжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнтэй зохион байгуулж МУ-ын ЗГ-ын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 140 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар илтгэл мэдээлэл танилцуулж, оролцогчидтой санал солилцсон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭРХЗҮЙН ОРЧИНГ ШИНЭЧЛЭХ, НЭГДСЭН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТААР ХАНГАХ** | | | | | | | |
| **Салбарын хуулийг шинэчлэх үйл ажиллагааны хүрээнд** | | | | | | | |
| 10. | *УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол МУ-ын ЗГ-ын 2024 оны 181 дүгээр тогтоол ЗГҮАХ-ийн 2.3.2.2 дахь заалт ЗГҮАХХАХТ 2.3.2.2.408* Эмнэлгийн тусламжийн тухай хууль шинэчлэн боловсруулах (Шинэчилсэн найруулга) | Батлагдсан үзэл баримтлал | 2016 онд батлагдсан Эрүүл мэндийн тухай хууль | Ажлын хэсгийг байгуулж, хууль боловсруулах ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гарган, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж, хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн байна. | Хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, батлуулан, хуулийн төслийг боловсруулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/43 дугаар тушаалаар Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Хуулийн төсөл боловсруулах хүрээнд дараах үйл ажиллагааг хийж байна.<br>• Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандах судалгааг хийж байна.<br>• Хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ хийж байна.<br>• Хууль дагаж гарах захиргааны актын судалгаа хийсэн<br>• Шинэчлэн боловсруулж байгаа Эрүүл мэндийн тухай хууь Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулт, Эмнэлгийн мэргэжилтний эрхзүйн байдлын тухай хуулийн ажлын хэсэгтэй зөвшилцөн хуулийн үйлчлэх хүрээг тус тусад нь хувааж тодорхойлсон.<br>Ажлын хэсгээс Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулаад байна. | 50 |
| 11. | *ЗГҮАХ-ийн 2.3.2.1 дэх заалт МУ-ын ЗГ-ын 2024 оны 181 дүгээр тогтоол* Цусны донорын тухай хуульд санал боловсруулах | Хуулийн төсөлд санал хүргүүлсэн байна. | Хуулийн төсөл | Хуулийн төсөлд санал авах арга хэмжээг зохион байгуулж, боловсруулан албан бичгээр хүргүүлсэн байна. | - | Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгээс санаачлан боловсруулсан "Цусны донорын тухай" хуулийн төсөлд Дотоод мэморандум 73-аар ЭМЯ-ны газар, хэлтсээс, эрүүл мэндийн байгууллагуудаас 5/1226 дугаар албан бичгээр санал авч нэгтгэн, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | (Анхдагч хууль) | | | | | удирдлагын багт танилцуулах уулзалтыг зохион байгуулж, МУ-ын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороонд Эрүүл мэндийн сайдын 1а/2785 албан бичгээр хүргүүлсэн.<br>Хууль шинэчлэхтэй холбоотой дараах хурлалд мэдээлэл бэлтгэн оролцсон байна.<br>• УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн хуралдаанд "Донорын хууль-ийн хэрэгжилтийн талаар мэдээлэл бэлтгэн танилцуулж, хэлэлцүүлсэн.<br>• УИХ-ын 2025 оны Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанд Цусны донорын хуулийн анхдагч хуулийн төслийг хэлэлцүүлж дэмжигдсэн.<br>УИХ-ын 05 дугаар сарын 22-ны хуралдаанд Цусны донорын хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдэх хурал болсон. | |
| 12. | *ЗГҮАХ-ийн 2.3.2.1 дэх заалт*<br>*МУ-ын ЗГ-ын 2024 оны 181 дүгээр тогтоол*<br>Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуульд санал боловсруулах (Анхдагч хууль) | Хуулийн төсөлд санал хүргүүлсэн байна. | Хуулийн төсөл | Хуулийн төсөлд санал авах арга хэмжээг зохион байгуулж, боловсруулан албан бичгээр хүргүүлсэн байна. | - | Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгээс санаачлан боловсруулсан Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах хуулийн төсөлд санал авах тухай албан бичгийг харьяа байгууллагуудад 5/1221, агентлагуудад 5/1226, мэргэжлийн салбар зөвлөлүүдэд 5/1227, төрийн бус байгууллагуудад 5/1228, 5/1229 тус тус дугаартай албан бичгээр 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр хүргүүлж хуулийн төсөлд тусгах 32 саналыг нэгтгэн хүргүүлсэн. | 100 |
| 13. | *УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол* | Батлагдсан үзэл баримтлал | Монгол Улсын Их Хурлын 2022 оны | Хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, ХЗДХ-ийн сайд, Эрүүл | Хуулийн төслийг боловсруулсан байна. | | 0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | *УИХ-ын 2022 оны 01 дүгээр тогтоол* Хүний генетикийн тухай хууль боловсруулах (Анхдагч хууль) | | 01 дүгээр тогтоол | мэндийн сайдаар батлуулсан байна. | | | |
| **Холбогдох хууль дагаж гарах эрхзүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр:** | | | | | | | |
| 14. | *Эрүүл мэндийн тухай хуулийн 8.7 дахь заалт* Эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээг боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээтэй хослуулан үзүүлэх журам, жагсаалтыг боловсруулж батлуулах | Батлагдсан журам, жагсаалт | - | Журмын төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, бэлтгэл ажлыг хангасан байна. | Журам, жагсаалтын төслийг боловсруулж, хэлэлцүүлэн батлуулсан байна. | “Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрэм”-ийг Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайд, Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн A/85, A/55, A/49 хамтарсан тушаалаар батлуулсан.<br>Тушаалыг эрх зүйн мэдээний нэгдсэн сан legalinfo цахим санд байршуулсан | 100 |
| 15. | *Эрүүл мэндийн тухай хуулийн 8.8 дахь заалт* Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг улсын хэмжээнд бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангах тусламж, үйлчилгээний чиглэл, хамрах хүрээг шинэчлэх | Батлагдсан тушаал | Хүрээ шинэчлэх тухай тушаалын төсөл | Улсын хэмжээнд мэргэжил аргазүйгээр хангах тусламж, үйлчилгээний чиглэл болон хүрээ, Нийслэлийн мэс заслын тусламжийн хүрээний тушаалын төслийг боловсруулж хэлэлцүүлсэн байна. | Улсын хэмжээнд мэргэжил аргазүйгээр хангах тусламж, үйлчилгээний чиглэл болон хүрээ, Нийслэлийн мэс заслын тусламжийн хүрээний тушаалуудыг батлуулсан байна | Тусламж, үйлчилгээний хүрээ, үйлчлэх эрүүл мэндийн байгууллагын хуваарь баталсан тушаалуудын зохицуулалт хоорондоо зөрчилтэй, алдаатай байгаагаас эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх үйл ажиллагаанд ул ойлголцол үүсэх, үүнээс үүдэлтэй үйлчлүүлэгчийг чирэгдүүлэх, цаашлаад эмчилгээний хожимдол үүсэх нөхцөл байдалд хүрсэн байгааг хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийж,<br>• “Улсын хэмжээнд эрүүл мэндийн бусад байгууллагыг арга зүйгээр хангах тусламж, үйлчилгээний хуваарь”<br>• “Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээнд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх хүрээ<br>• "Зүрхний шигдээсийн үед судсан дотуурх оношилгоо, эмчилгээ хийх эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээ"<br>• "Нийслэлд гемодиализийн тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээ"<br>шинэчлэн боловсруулж ЭМС-ын 2025 оны А/242 дугаар тушаалаар баталсан. | |
| 16. | *Эрүүл мэндийн тухай хуулийн 8.9 дэх заалт* Хүний амь насанд аюултай, хөгжлийн бэрхшээлд хүргэдэг ховор тохиолдох өвчин, эмгэгийг тодорхойлох аргачлалыг боловсруулж батлуулах | Батлагдсан тушаал | - | Аргачлал боловсруулах ажлын хэсгийг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангана. | Аргачлалын төсөлд санал авах үйл ажиллагаа зохион байгуулж, батлуулсан байна. | | 0 |
| 17. | *Эрүүл мэндийн тухай хуулийн 16.22 дахь заалт* Эмнэлэг хяналтын комиссын ажиллах журам, гишүүдэд олгох урамшууллын хэмжээний төслийг боловсруулж, батлуулах | Засгийн газрын тогтоол | - | Эмнэлэг хяналтын комиссын ажиллах журам, гишүүдэд олгох урамшууллын хэмжээний төслийг боловсруулж, яамдаас санал авч ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн байна. | - | Эмнэлэг хяналтын комиссын ажиллах журам, гишүүдэд олгох урамшууллын хэмжээг Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулах хүрээнд 2025 оны 2 дугаар сард Нийслэлийн Баянзүрх, Хан-Уул дүүргийн ЭМТ, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудын нэгдсэн эмнэлгийн дэргэдэх "Эмнэлэг хяналтын комисс"-ын үйл ажиллагаатай танилцсан. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Эмнэлэг хяналтын комиссын ажиллах журам, гишүүдэд олгох урамшууллын хэмжээ” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан.<br>Байнгын асаргаа тогтоож буй эмнэлэг хяналтын комиссын гишүүдэд олгох урамшууллын зардлыг Нийгмийн халамжийн сангаас гаргахаар Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хуулийн төслүүдэд хуулийн төсөлд тусгуулахаар санал хүргүүлсэн. | |
| 18. | *Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.4 дэх заалт* Эмнэлэг болон сувиллын орны дээд хязгаарыг тогтоох | Батлагдсан тушаал | | Улсын хэмжээнд хэвтүүлэн эмчлэх ор ашиглалтын судалгаа хийсэн байна. | Эмнэлэг болон сувиллын орны дээд хязгаарыг тогтоох тушаалын төслийг боловсруулж, хэлэлцүүлж, батлуулсан байна. | Эрүүл мэндийн хуулийн 8.1.4.хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг салбарын хэмжээнд төлөвлөх, зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагын байршил, бүтэц, зохион байгуулалт, тусламж, үйлчилгээний төрөл, шатлал, эмнэлгийн болон сувиллын орны дээд хязгаарыг тогтоох;” гэж хуульчилсны дагуу 2026-2029 оны эмнэлгийн тусламж, үйлчилгээнд ашиглах орны дээд хязгаарыг батлах эрхзүйн үндэслэлийн хүрээнд хэвтүүлэн эмчлэх орыг дахин төлөвлөхөд нотолгоот мэдээллийг гаргах зорилгоор эмнэлгийн орны ашиглалтын байдалд судалгаа дүн шинжилгээ, хийх ажлыг ЭМХТ-тэй хамтран гүйцэтгээд байна. | 100 |
| 19. | *Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 11.2 дахь заалт* Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, үзлэгийн | Батлагдсан тушаал | - | Хууль дагаж гарах журам, жагсаалтыг боловсруулах ажлыг бүрэлдэхүүн, ажиллах, удирдамжийг баталгаажуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган, төслүүдийг боловсруулсан байна. | Хууль дагаж гарах журам, жагсаалтын төслийг захиргааны хэм, хэмжээний акт боловсруулах журмын дагуу хэлэлцүүлж, батлуулж, бүртгүүлсэн байна. | Хууль дагаж гарах журам, жагсаалтыг боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа:<br>• Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/80 дугаар тушаалаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль дагаж гарах журам, шаардлага, жагсаалт, үзлэгийн хуудсын загвар боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын удирдамжийг баталсан. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуудасны загвар, үзлэг явуулах эрх бүхий эмнэлгийн байгууллагын жагсаалт, тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эм, бэлдмэл, тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийн жагсаалт, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журам боловсруулж батлуулах | | | | | • Ажлын хэсгийн хурлыг нэгдсэн хурлыг 1 удаа зохион байгуулж, эрүүл мэндийн шаардлага тавигдах мэргэжлийн чиглэлүүдийн түвшинд (нүд, чих, хамар, хоолой, мэдрэл, гэмтэл) 5 удаагийн уулзалт зохион байгуулаад байна.<br>• Журам боловсруулах хүрээнд “Зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж, үзүүлэх журам”-ын талаар ОУ-ын судалгаа хийсэн.<br>• Жолооны эрх ба эрүүл мэндийн хязгаарлалтын талаарх ОУ-ын туршлагын судалгаа хийсэн.<br>• Оросын Холбооны Улс, Герман Улсын тээврийн хэрэгсэлд байх эмнэлгийн анхан шатны тусламжийн иж бүрдэлд байх эм, эмнэлгийн хэрэгслийн мэдээллийг гаргасан.<br>Ажлын хэсэг жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, үзлэгийн хуудасны загвар, тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийн жагсаалтын төслийг боловсруулаад байна. | |
| 20. | *Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 25.2* Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж, үзүүлэх түүнийг эрүүл мэндийн байгууллагад | Батлагдсан тушаал | ЭМС, ХЗДХС, хамтарсан 2019 оны А/142, А/47 дугаар | Нөхцөл байдлыг судалж, журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, ХЗДХС-д хүргүүлж, саналыг тусган батлуулсан байна. | - | Эрүүл мэндийн сайд, Хууль, зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/211, А/218 дугаар тушаалаар батлагдсан. Эрүүл мэндийн байгууллагуудад 5/2945 дугаар албан бичгээр хэрэгжилтийг хангах чиглэлийг хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эмчлэх, хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах | | | | | | |
| ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ, ОРОН НУТГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ ЧАДАВХЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ | | | | | | | |
| 21. | Эрүүл мэндийн байгууллага болон шатлал хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх эрхзүйн орчныг шинэчлэх, зохицуулалтыг сайжруулах арга хэмжээг авах | Батлагдсан тушаал | ЭМС-ын 2021 оны А/183 дугаар тушаал | Өвчтөн шилжүүлэх журмын төслийг боловсруулж батлуулсан байна. | Эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх нэгдсэн удирдлага зохион байгуулалтыг тогтолцоог бүрдүүлсэн байна. | Эрүүл мэндийн байгууллага хооронд өвчтөн илгээх журмыг шинэчлэх хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан.<br>• Өвчтөн илгээх 13А, 13Б маягтыг шинэчлэн 89 А, Б маягт болгон өгөгдлийг шинэчлэн боловсруулсан.<br>• Эмнэлэг хооронд цахимаар өвчтөн шилжүүлэх үйл ажиллагааг хавдрын тусламж, үйлчилгээнд турших үйл ажиллагааг 06 дугаар сараас зохион байгуулж эхэлсэн бөгөөд туршилтын үр дүнд үндэслэн өвчтөн шилжүүлэх үйл ажиллагааг журамлаж тушаалаар батлана.<br>• Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/102 дугаар тушаал Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах ажлын хэсгийн хүрээнд анхан шатны бүртгэлийн маягтын бүртгэлийн давхардлыг арилгах дүн шинжилгээ хийгдэж байна. | 30 |
| 22. | Алсын дуудлагаар очиж эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрхзүйн орчныг шинэчлэх, нэгдсэн удирдлага зохион байгуулалтын | Батлагдсан тушаал<br><br>Зохицуулалт хийдсэн тоон мэдээлэл | ЭМС-ын 2014 оны А/263 дугаар тушаал | Алсын дуудлагын журмын төслийг боловсруулж батлуулсан байна. | Нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах зохицуулалттай болсон байна. | Алсын дуудлагаар эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журмын төслийг боловсруулж, Эрүүл мэндийн яамны вэб хуудсанд санал авахаар байршуулсан.<br>бөгөөд салбарын цахим шинэчлэлийн хүрээнд программын нийцэл бүрэн хангагдсан үед мэдээллийн урсгалыг журамд нэмж оруулах шаардлага хүлээгдэж байна. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтолцоог бүрдүүлэх журмыг шинэчлэх | | | | | | |
| 23. | Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах арга хэмжээг зохион байгуулах | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | | Холбогдох аймаг, орон нутгийн төвлөрлийг сааруулах тусламж, үйлчилгээний хүний нөөц, тоног төхөөрөмжийн судалгаа хийж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж батлуулсан байна. | Төвлөрлийг сааруулах хүрээнд хүний нөөцийг чадавхжуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэх, ханган нийлүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн зохицуулалтыг хангаж ажилласан байна. | Төвлөрлийг сааруулах хүрээнд хүний нөөцийг чадавхжуулах, шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг хийсэн. 5 чиглэлээр 63 эмч мэргэжилтнийг бэлтгэх, 26 нэр төрлийн 150 ширхэг тоног төхөөрөмж шаардлагатай судалгаа гарсан. | 50 |
| 24. | Орон нутагт нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах үндэсний багийг ажиллуулах. (хавдар, эх барих эмэгтэйчүүд, ангиография, гэмтэл согогийн мэс засал) | Орон нутагт ажилласан багийн тоо | Хэнтий Нэгдсэн эмнэлэг, 5 БОЭТ-д 7 үндэсний баг ажиллаж эхэлсэн | Орон нутагт ажиллах үндэсний багийн хуваарь гаргаж, батлуулсан байна. | Үндэсний багийн үйл ажиллагааны нэгдсэн зохицуулалтыг хангаж, 12 багийг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад ажиллуулсан байна. | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах хүрээнд төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт ачаалал, хүлээгдэл өндөртэй байгаа тусламж, үйлчилгээ болон тухайн тусламж, үйлчилгээний чиглэлээр орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөц, тоног төхөөрөмж, чадавхын судалгааг гарган орон нутагт нэвтрүүлэх тусламж, үйлчилгээний чиглэлийг тодорхойлж, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдээс "Төвлөрөл сааруулах үндэсний баг"-ийг зүрхний хэм судлал, ангиографи, гэмтэл согог судлал, хавдар судлалын чиглэлээр 2024 оны А/367 дугаар тушаалаар байгуулсан.<br>2025 оны А/119 дүгээр тушаалаар "Хүүхэд, нярай, хүүхэд нярайн ургийн мэс заслын үндэсний багийг байгуулж, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/112 дугаар тушаалаар "Төвлөрлийг сааруулах үндэсний багийн ажиллах журам"-ыг баталсан. Үндэсний багуудыг3-8 хүний бүрэлдэхүүнтэйгээр Өмнөговь, Орхон, Ховд, Дорнод, Өвөрхангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Хөвсгөл аймагт томилогдон ажиллах хуваарь гаргаж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өнөөдрийн хүртэл давхардсан тоогоор 136 эмч, эмнэлгийн мэргэжилтэн үндэсний багийн хүрээнд ажилласан байна.<br>Дээрх орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг чадахвжуулах үйл ажиллагааны хүрээнд Дорнод аймаг дахь БОЭТ, Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэг, Өвөрхангай аймаг дахь БОЭТ, Өмнөговь аймаг дахь БОЭТ, Ховд аймаг дахь БОЭТ, Орхон аймаг дахь БОЭТ ангиографийн оношилгоо, эмчилгээг хийх чадамж бүрдсэн бөгөөд Эрүүл мэндийн сайдын А/242 дугаар тушаалаар зүрхний шигдээсийн үед судсан дотуурх оношилгоо, эмчилгээ хийх эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээг баталлаа.<br>Төвлөрөл сааруулах үндэсний баг ажилласан орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад өнөөгийн байдлаар хавдрын ангиографийн оношилгоо 121 хүнд, хавдрын ангиографийн эмчилгээ 68 хүнд, зүрхний шигдээс болон бусад зүрхний архаг эмгэгтэй 228 хүнд, ангиографийн оношилгоо , ангиографийн эмчилгээг 143 хүнд, тархины судасны эмгэгтэй 111 хүнд ангиографийн оношилгоог 15 хүнд ангиографийн эмчилгээ хийсэн байна. | |
| 25. | Дүрс оношилгооны зайн оношилгооны төвийн үйл ажиллагааны журмыг батлуулж хэрэгжилтийн зохицуулалтыг хангах. | Батлагдсан журам, үйлчилгээ авсан хүний тоо | | Зайн оношилгооны төвийн үйл ажиллагааны журмыг боловсруулж батлуулсан байна. | Зайн оношилгооны төвийн үйл ажиллагааны нэгдсэн зохицуулалтыг хангахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | Улсын хоёрдугаар төв эмнэлэгт дүрс оношилгооны "Зайн оношилгооны төв" байгуулж, аймаг, орон нутгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төвийн дүрс оношилгооны хариуг зайнаас бичих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үндсэн үйл ажиллагаа бүхий алба байгуулсан.<br>"Зайн оношилгооны төв"-д 6 хүний орон тоо бүхий эмч, мэргэжилтнүүд | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Гэмтэл согог судлалын үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлгээс ажиллаж байна.<br>Зайн оношилгооны төвийн үйл ажиллагааны журмыг боловсруулан 5 дугаар сарын 10-ны өдрөөс ЭМЯ-ны газар хэлтсээс санал авч байна. | |
| 26. | Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ эрхзүйн орчныг шинэчлэх | Батлагдсан журам | | Орон нутагт хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний нөхцөл байдлын судалгаа хийсэн байна.<br>Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх журмын төслийг боловсруулсан байна. | Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг батлуулсан байна.<br>Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний чадавхыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2015 оны А351 дүгээр тушаалыг шинэчлэх ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А209 тушаалаар байгуулж хавдрын тусламж, үйлчилгээг орон нутагт сайжруулах чиглэлээр ажиллаж байна.<br>Орон нутагт хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний нөхцөл байдлын судалгааг хийж ажиллах орны зохицуулалтыг хийсэн.<br>2024 онд хөнгөвчлөх эмчилгээний 229 ор ажиллаж байсан бол 306 болгож нэмэгдүүлсэн. Хан-Уул ЭМТ, Баянгол ЭМТ-үүдэд хавдрын эмчилгээний нэгж байгуулагдсан. | 50 |
| 27. | Хавдрын туяа эмчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад чиглэсэн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийг гаргах | Батлагдсан төлөвлөгөө, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | | Туяа эмчилгээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахад нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | Хавдрын туяа эмчилгээний урт хугацааны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг нийт 3 удаа хуралдаж, төлөвлөгөөний үндэслэл буюу хэрэгцээ шаардлага, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон. Ажлын хэсгээс гарсан саналын дагуу туяа эмчилгээ, цөмийн оношилгоо, эмчилгээний хэсгийн дэд бүлэг байхаар төслийг боловсруулсан. | 50 |
| 28. | Эрүүл мэндийн салбарын | Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, | - | Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн зохион | Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн зохион | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/72 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийн нэгдсэн зохион байгуулалтаар хангах | үр дүнгийн тайлан | | байгуулалтаар хангах менежерийн томилох, хавдрын тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулахад чиглэсэн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна. | байгуулалтаар хангаж, хавдрын тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулахад төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцсон байна. | дугаар “Бүсийн менежер томилох тухай” тушаалаар 6 бүс, Улаанбаатар хотын бүсийн менежерүүд томилогдсон. Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн “Хавдар судлалын үндэсний төвд бүс хариуцсан менежерүүд ажиллах удирдамж”-ийн дагуу эн тэргүүнд хавдрын тусламж, үйлчилгээний бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийг гаргахаар ажилласан. Энэ ажлын хүрээнд нийт 6 удаа танхимаар ажиллаж, хавдрын тусламж, үйлчилгээний бүсчилсэн хөгжлийн зураглалыг гаргасан. Хойд бүсийн бүсчилсэн хөгжлийн Засгийн газрын хуралдаанд 2025.04.28-ны өдөр оролцсон ба хуралдаанаар Эрдэнэт хотын “Эрдэнэт Медикал” эмнэлгийг Хавдар судлалын үндэсний төвийн харьяа оношилгоо, эмчилгээний төв болгох асуудал дэмжигдсэн | |
| 29. | *ЗГҮАХ 2.3.2.2.406* Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний иргэний эрүүл мэндийн хяналт хийх, эргэн мэдээлэх чадавхыг бэхжүүлнэ. | Эргэн мэдээлэх тогтолцооны сургалтын хөтөлбөрт хамрагдалтын хувь | | - | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нийт эмнэлгийн мэргэжилтний 10 хувь сургалтын хөтөлбөрт хамрагдсан байна. | Хэрэгжүүлэх хугацаа болоогүй | |
| ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД: | | | | | | | |
| 30. | Эрүүл мэндийн байгууллагын удирдлагуудыг хамруулсан “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний | Сургалтын тайлан | - | - | “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнгийн гүйцэтгэлийн үнэлгээ” сэдэвт удирдах ажилтны сургалтын зохион байгуулсан байна. | Хэрэгжүүлэх хугацаа болоогүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чанар, үр дүнгийн гүйцэтгэлийн үнэлгээ" удирдах ажилтны сургалт зохион байгуулах | | | | | | |
| 31. | Дэлхийн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдрийг тэмдэглэх | Зохион байгуулсан арга хэмжээний тайлан | | | Дэлхийн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдрийг тэмдэглэн өнгөрүүлсэн байна | Хэрэгжүүлэх хугацаа болоогүй | |
| 32. | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын ерөнхий шалгуур үзүүлэлт боловсруулан батлуулах | Батлагдсан тушаал | - | - | Чанарын ерөнхий шалгуур үзүүлэлтийг эрүүл мэндийн сайдын тушаалаар баталж, эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн байна. | Хэрэгжүүлэх хугацаа болоогүй | |
| ЭХ БАРИХ, ЭМЭГТЭЙЧҮҮДЭД, ХҮҮХЭД , НЯРАЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХЗҮЙН ОРЧНЫГ ШИНЭЧЛЭХ ХҮРЭЭНД: | | | | | | | |
| 33. | Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэл, амьгүй төрөлтийг тооцох, бүртгэх, хэлэлцэх, тандах журмыг шинэчлэх | Батлагдсан тушаал | ЭМС-ын 2022 оны A/550 дугаар тушаал | Журмын боловсруулах бэлтгэл ажлыг хангаж, төслийг боловсруулсан байна. | Журмын төслийг хэлэлцүүлж, батлуулсан байна. | 2024 оны 04 дүгээр сард байгуулагдсан 23 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг "Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэл, амьгүй төрөлтийг тооцох, бүртгэх, хэлэлцэх, тандах журам"-ын төслийг шинэчлэх ажлын хүрээнд ДЭМБ-ийн аргачлалын дагуу "Эхийн болон перинаталь эндэгдлийн тандалт, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх баг"-ийг ЭХЭМҮТ, Амгалан амаржих газар, Ховд, Увс, ӨМ аймагт байгуулан туршилт хийж журмын төслийг боловсруулсан. | 70 |
| 34. | Үр хөндөлтийг зохицуулах журмыг шинэчлэх | Батлагдсан тушаал | ЭМС-ын 2014 оны 148 дугаар тушаал | Журмын боловсруулах бэлтгэл ажлыг хангаж, төслийг боловсруулсан байна. | Журмын төслийг хэлэлцүүлж, батлуулсан байна. | Журмын төслийг боловсруулж байна. | 70 |
| 35. | Хүүхдийн гэрийн эргэлтийн тусламж, үйлчилгээний журам | Батлагдсан журам | - | - | Хүүхдийн гэрийн эргэлтийн тусламж, үйлчилгээний журам боловсруулж батлуулсан байна. | Хүүхдийн гэрийн эргэлтийн тусламж, үйлчилгээний журам боловсруулж байна. | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж батлуулах | | | | | |
| 36. | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг хэлэлцэх журам шинэчлэх | Батлагдсан журам | 2021 оны 263 дугаар тушаал | Журам боловсруулах ажлын хэсгийг байгуулж, журмын төслийг боловсруулсан байна. | Журмын төсөлд санал авч батлуулсан байна. | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг хэлэлцэх журмын Эмнэлзүй-эмгэг судлалын конференци зохион байгуулах, Хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн хэсгийг боловсруулсан. | 70 |
| АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНД ҮЗҮҮЛЭХ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХЗҮЙН ОРЧИНГ БҮРДҮҮЛЖ, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД: | | | | | | | |
| 37. | *ЗГҮАХХАХТ 2.3.2.8.422* Эрүүл насжилтыг дэмжих зорилгоор ахмад настны цогц үнэлгээг нэвтрүүлэх, үнэлгээний дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлийг боловсруулж, хэрэгжүүлэх | Үнэлгээнд хамрагдсан ахмад настны хувь Үйлчилгээ авсан ахмад настны сэтгэл ханамжийн хувь | - | Сургалт зохион байгуулсан байна. | Нийт ахмад настны 10% нь цогц үнэлгээнд хамрагдсан байна. Үйлчилгээ авсан ахмад настны сэтгэл ханамжийн судалгаа хийгдсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/22 тушаалаар батлагдсан “Ахмад настны цогц тусламж үйлчилгээний заавар”-ын дагуу цогц үнэлгээг эрүүл мэндийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагад түшиглэн зохион байгуулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор г 2025 оны 4 дүгээр сарын 22 ноос 4 дүгээр сарын 28 -ны өдрүүдэд Баруун бүсийн Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс аймгуудад сургалт зохион байгуулсан. Улаанбаатар хотод 2025 оны 06 дугаар сарын 26,27-ны өдрүүдэд Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт зохион байгуулахаар төлөвлөж байна. ЭТБГ-ын даргын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 5/3069 дугаартай "Хамтран ажиллах тухай" албан бичгийг Нийслэлийн эрүүл мэндийн газар хүргүүлсэн.<br>Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, ЭМХТ-өөр батлуулан ЭМХТ-ийн HRDS програмд байршуулсан. | 100 |
| 38. | *ЗГҮАХ 2.1.1.25.208* Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг | Хүргүүлсэн саналын тоо | - | - | Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тодорхойлох олон улсын ангиллыг (ICF) үе шаттай нэвтрүүлэх ажлын хэсэгт орж | Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг боловсруулж, турших үйл ажиллагааны хүрээнд ЭМЯ, ГБХНХЯ хамтран уулзалтуудыг зохион байгуулж, олон улсын үйлдлийн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоох олон улсын аргачлалыг нэвтрүүлж зураглал гарган туршина. | | | | ажиллан сургалтын хөтөлбөрт санал хүргүүлнэ | ангилал (ICF)-ыг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлэх үндсэн байгууллагаар ГБХНХЯ ажиллах, тус яамнаас ажлын хэсэг байгуулагдахаар шийдвэрлэгдэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тусгагдсан.<br>ЭМЯ-аас тус ажлын хэсэгт ажиллах албан тушаалтны нэрийг 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 5/2764 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | |
| 39. | *ЗГҮАХ 2.1.1.21.199*<br>Ахмад настны цогц үнэлгээ хийх, удирдлага, арга зүйгээр хангах журам, асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам, ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээний төлбөр, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох журмыг батлуулж хэрэгжилтийг хангах | Боловсруулсан журмын тоо | - | - | Холбогдох эрхзүйн орчныг бүрдүүлэх зорилгоор 2 журам батлагдсан байна. | Эрүүл насжилтыг дэмжих зорилгоор ахмад настны цогц үнэлгээг хийх эрхзүйн орчныг бүрдүүлэх зорилгоор дараах шийдвэрүүдийг батлуулаад байна.<br>• Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/76,515, А/75,514 дүгээр хамтарсан тушаалаар "Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам", "Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журам"-ыг батлан Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн.<br>• Мөн 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн "Журам батлах тухай" А/28, А/27 тоот хамтарсан тушаалаар "Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах журам"-ыг баталсан.<br>• "Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам"-ын хэрэгжилтийг хангахад чиглэсэн "Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйл ажиллагааг дэмжих мэргэжлийн хамтарсан баг, орон нутгийн мэргэжлийн хамтарсан багаас | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөө" -г Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга хамтран баталсан.<br>• ЭМЯ-наас эрүүл мэндийн байгууллагуудад албан бичгээр хүргүүлсэн бөгөөд Эрүүл мэндийн сайдын Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээнд ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулах, хуулийн хэрэгжилтийг хангуулах, тайлан мэдээллийг харилцан солилцох талаар үйл ажиллагаа тусгасан. | |
| 40. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн үйл ажиллагааг хангах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулж, зөвлөлийн үйл ажиллагааг хангасан байна. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт бүрэн хангасан байна. | Төрийн нарийн бичгийн дарга, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн даргын баталсан хөтөлбөрийн дагуу 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөл"-ийн 1 дүгээр улирлын хурлыг зохион байгуулсан<br>Дэд зөвлөлийн гишүүдийн 76 хувийн ирцтэйгээр 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.<br>"Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах тухай" Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 2/2770 дугаар албан бичгээр Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагуудад төлөвлөгөөг хүргүүлсэн.<br>Дэд зөвлөлийн ажлын төлөвлөгөөний дагуу - УНТЭ-тэй хамтран 2025 оны 2 дугаар сард Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 76 эцэг эхийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.<br>- ЭХЭМҮТ, ГССҮТ, СЭМҮТ, УГТЭ-тэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй 476 хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 5/2177 дугаартай "Хамтран ажиллах тухай" албан бичгийг төрөлжсөн мэргэшлийн төв эмнэлгүүдэд хүргүүлсэн.<br>Дэд зөвлөлийн гишүүн "Эрхэм нандин сувд" ТББ-тай хамтран Энэтхэг улсын эмч нартай ЭХЭМҮТ, ГССҮТ-ийн эмч нарын хамтарсан үзлэг, эмчилгээ зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан. | |
| 41. | Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалтыг шинэчлэх | Батлагдсан тушаал | ЭМ-ийн сайд, ГБХНХ-ын сайдын хамтарсан тушаал 2021 оны А/807 216 | Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалтыг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан байна_ | Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалтын төсөлд санал авч, батлуулсан байна. | Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулж Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн А/68,А/62 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан.<br>Тушаалыг эрх зүйн мэдээний нэгдсэн санд бүртгүүлэн яамны цахим хуудсанд байршуулсан.<br>Эмнэлгийн тусламжийн бодлогын даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн "Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай" 5/1524 албан бичгээр Аймаг нийслэлийн ЭМГ-т хүргүүлсэн. | 100 |
| 42. | Нийслэлийн хэмжээнд ахмад настны үзлэгийн зохион байгуулах | Батлагдсан тушаал | - | Нийслэлд 2-3 дугаар сард ахмад настны үзлэг зохион байгуулах шийдвэрийг батлуулж, хэрэгжилтийг хангуулахад удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна. | - | Нийслэлийн хэмжээнд ахмад настны үзлэгийн зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан:<br>• Нийслэлд "Ахмад настны үзлэгийг зохион байгуулах ажлын удирдамж"-ийг боловсруулж Эрүүл мэндийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/28 дугаар тушаалаар батлуулсан.<br>• Ахмад настны үзлэгийг зохион байгуулах үйл ажиллагаанд мэргэжил аргазүйгээр хангах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зорилгоор нийслэлийн төрийн өмчийн бүх байгууллагуудад цахим хурлыг зохион байгуулж явцын хяналтыг 7 хоног хийж тайланг гаргасан. Нийслэлийн хэмжээнд 2 сарын хугацаанд зохион байгуулагдсан үзлэгт **7337** ахмад хамрагдаж, 1593 ахмадыг дүүргийн эрүүл мэндийн байгууллага, 999 ахмадыг төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн хяналтад авсан. | |
| УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД: | | | | | | | |
| 43. | Уламжлалт анагаах ухааны өвчний бүлэг, оношийн ангилал, кодыг шинэчлэх | Батлагдсан тушаал | ЭМС-ийн 2022 оны А/55 тоот тушаал | Уламжлалт анагаах ухааны өвчний бүлэг, оношийн ангилал, кодыг шинэчлэн боловсруулж батлуулсан байна. | - | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/61 тоот тушаалаар Уламжлалт анагаах ухааны өвчний бүлэг, оношийн ангилал, кодыг шинэчлэн батлулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг танхимаар 2 удаа, цахимаар 3 удаа хуралдаж дэд бүлэгт хуваагдан ажилласан. Уламжлалт анагаах ухааны өвчний бүлэг, оношийн ангилал, кодыг шинэчлэн боловсруулж мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг, яамны газар, хэлтсийн дарга нараас санал авч байна. | 70 |
| 44. | Монголын уламжлалт анагаах ухааны анхан болон лавлагаа шатлалд үзүүлэх тусламж үйлчилгээний зааврыг шинэчлэх | Батлагдсан тушаал | ЭМС-ын 2019 оны А/378 тушаал | Анхан болон лавлагаа шатлалд үзүүлэх тусламж үйлчилгээний төслийг боловсруулсан байна. | Анхан болон лавлагаа шатлалд үзүүлэх тусламж үйлчилгээний төслийг хэлэлцүүлж, батлуулсан байна. | Анхан болон лавлагаа шатлалд үзүүлэх тусламж үйлчилгээний жагсаалтын төслийг боловсруулсан. | 50 |
| 45. | *ЗГҮАХ-3.3.5.3.800* Нүүдэлчин дэлхийн соёлын наадмыг зохион байгуулах | Арга хэмжээний тайлан | 2 | | Нүүдэлчин дэлхийн соёлын наадамд оролцож, уламжлалт анагаах ухааныг сурталчлах арга хэмжээг | Хэрэгжүүлэх хугацаа болоогүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулсан байна. | | |
| ГАМШИГ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД: | | | | | | | |
| 46. | *ЗГҮАХ 2.3.2.2.407* Яаралтай, түргэн тусламжийн тогтолцоог шинэчлэх, үндэсний түргэн тусламжийн төв байгуулах | Төслийн гүйцэтгэлийн хувь | 10 хувь | Түргэн тусламжийн төвийн үйл ажиллагааны дүрмийг боловсруулж, техникийн ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлсэн байна. | Төслийн гүйцэтгэл 30 хувьтай байна. | Австри Улсын Ванмед зөвлөх үйлчилгээний компанитай хамтран Яаралтай түргэн тусламжийн тогтолцоог шинэчлэх ажлын хүрээнд хэрэгцээний судалгааг хийсэн. Үндэсний хэмжээний нэгдсэн түргэн тусламжийн төвийг Улаанбаатар хотод байгуулах замаар Монгол Улсад түргэн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилготойгоор одоогийн үйл ажиллагааг цогцоор нь судлах шаардлагатай байсан ба үүний хүрээнд ТТҮТ нь яаралтай, түргэн тусламжийн сүлжээн дэх бүхий л байгууллагатай шууд холбоо тогтоодог нэгдсэн сүлжээ болох боломжийг судалсан. ТТҮТ-д байвал зохих дэд бүтэц, тоног төхөөрөмжийг нарийвчлан судлан төсвийг 3 хэсэгт хуваан тодорхойлсон. Мөн түргэн тусламжтай холбоотой үйл ажиллагааны зохицуултын одоогийн нөхцлийг тодорхойлсон ба үйл ажиллагааны зохицуулалтыг хэрхэн хийх талаар судалж тайлангаа гаргасан. Үүнийг хийснээр яаралтай, түргэн тусламжийн тогтолцоог шинэчлэх, үндэсний түргэн тусламжийн төв байгуулах хэрэгцээний бүх чиглэлийг хамарсан судалгаа бэлэн болж хэрэгжүүлэх үйл ажиллагаа эхлэх гэж байна. | 50 |
| 47. | *МУХТЖҮЧ. 2.2.4.* Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хүн амд эмнэлгийн тусламж | Батлагдсан тушаал | - | "Эмнэлгийн яаралтай тусламжийн үндэсний баг"-ийг батлуулсан байна. | - | Тушаалын төслийн боловсруулан Яаралтай тусламж судлалын мэргэжлийн салбар зөвлөлөөс санал авахаар илгээсэн. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээ үзүүлэх "Эмнэлгийн яаралтай тусламжийн үндэсний баг"-ийг байгуулах | | | | | | |
| 48. | Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дайчилгааны төлөвлөгөөг боловсруулах | ЗГ-ын тогтоол | - | Төлөвлөгөөний төслийг боловсруулж, санал авч батлуулсан байна. | - | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн мн/13 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн яамны дайчилгааны төлөвлөгөөг батлуулсан. | 100 |
| 49. | *Алсын хараа 2050 2.2.17.* Эмнэлгийн яаралтай тусламжийн үед агаарын тээвэр ашиглах эрхзүйн орчныг бүрдүүлэх, орон нутагт агаарын яаралтай туламжийн бэлэн байдлыг хангах | Батлагдсан тушаал | Журмын төсөл | Эмнэлгийн яаралтай тусламжийн үед агаарын тээвэр ашиглах журмын төслийг боловсруулж хэлэлцүүлж, санал авч батлуулсан байна. | 5 БОЭТ болон Хэнтий аймагт онгоц буух талбайтай болгоход чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг авсан байна. | Эмнэлгийн яаралтай тусламжийн үед агаарын тээвэр ашиглах журмын төслийг боловсруулж Яаралтай тусламж судлалын мэргэжлийн салбар зөвлөлөөс санал авахаар хүргүүлсэн. | 50 |
| | **ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТ ЗААВАР ШИНЭЧЛЭХ, НЭГДСЭН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТААР ХАНГАХ** | | | | | | |
| 50. | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандартуудыг шинэчлэх | Батлагдсан стандарт ын тоо | СЭМТ-ийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 5081:2013 ӨЭМТ-ийн бүтэц үйл ажиллага | Өрх, сумын эрүүл мэндийн төвийн стандартыг шинэчлэн боловсруулж батлуулсан байна. | - | Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн стандартыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг ЭМС-ын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/512 дугаар тушаалаар баталж, 2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн А/143 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2025 оны 2-5 сард нийт 4 удаа хурал хийж одоогийн хэрэгжиж байгаа анхан шатны тусламж, үйлчилгээний бодлогын нөхцөл | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | аны стандарт MNS 5292:2017 | | | байдлын дүн шинжилгээ хийх, Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн MNS 5081:2013, өрхийн эрүүл мэндийн төвийн MNS 5292:2017 стандартын шаардлагын бусад хяналт, үнэлгээний шалгууртай (Эрүүл мэндийн сайдын А/383, А/122, А/321, А/321, магадлан итгэмжлэлийн болон) нийцлийг үнэлэх, Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн стандартын төсөл боловсруулах,, 2-3 өрх, сумын эрүүл мэндийн төвд турших үнэлэх, төсөлд холбогдох эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг холбоодын саналыг авч тусгах, төсөлд холбогдох байгууллага, нийгэмлэг, холбоодыг хамтарсан цахим хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг арга хэмжээг тусгаж төлөвлөгөө боловсруулсан. Мөн ДЭМБ-д тус ажлын хэсгийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах талаар удирдамж, хүсэлт хүргүүлсэн. Тайлант хугацаанд сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн стандартын төслийг ажлын хэсгийн үнэлгээний ажил хийгдэж байна, мөн 2 стандартын төсөл боловсруулж байна. | |
| 51. | | | - | Үр хөндөлтийн цогц тусламж үйлчилгээ" стандартыг шинэчлэн боловсруулсан байна. | Үр хөндөлтийн цогц тусламж үйлчилгээ" стандартыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | Үр хөндөлтийн цогц тусламж үйлчилгээ" стандартыг шинэчлэн боловсруулж, байна. | 50 |
| 52. | | | Эмчилгээ оношилгооны түгээмэл үйлдэл MNS 4621:2008 | Уламжлалт анагаах ухааны түгээмэл үйлдлийн стандартыг боловсруулсан байна. | Уламжлалт анагаах ухааны түгээмэл үйлдлийн стандартын төсөлд санал авч батлуулсан байна. | | 30 |
| 53. | | | | Эх барих, эмэгтэйчүүд судлалын түгээмэл үйлдлийн стандартын төсөлд санал авсан байна. | Эх барих, эмэгтэйчүүд судлалын түгээмэл үйлдлийн стандартыг СХЗГ-аар батлуулсан байна | Эх барих, эмэгтэйчүүд судлалын түгээмэл үйлдлийн стандартыг боловсруулж СХЗГ-хүргүүлэхэд бэлэн болсон. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| 54. | | | | Сувилахуйн түгээмэл үйлдлийн стандартын төсөлд санал авсан байна. | Сувилахуйн түгээмэл үйлдлийн стандартыг СХЗГ-аар батлуулсан байна. | Түгээмэл үйлдлийн стандартын ерөнхий сувилахуйн үйлдлүүдийн стандартыг Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээний стандартчиллын техникийн хорооны 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Техникийн хорооны гишүүдийн саналыг тусгаж, дахин хэлэлцүүлэх шийдвэр гарсан. Техникийн хорооны 5 гишүүний 11 саналыг бичгээр авч баталгаажуулан тусгасан. Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээний стандартчиллын техникийн хорооны ээлжит хурлаар хэлэлцүүлнэ | 50 |
| 55. | Эмчилгээ, оношилгооны эмнэлзүйн заавсрыг боловсруулах | Батлагдсан тушаал | - | УАУ-ны дотрын 3 өвчний оношилгоо, эмчилгээний заавсрыг боловсруулж батлуулсан байна. | - | Хий, шар, бадганы өвчний үеийн идээ унд, явдал мөрийн заавсрыг боловсруулан харьяа байгууллагуудаас 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 5/2253 дугаартай албан бичгээр санал авч хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br>Тус заавар нь шинэчлэгдэн гарах оношийн ангилал, кодтой уялдаатай гарах учраас тушаал батлагдахыг хүлээж байна. | 50 |
| 56. | | | - | - | УАУ-ны мэдрэлийн 2 өвчний оношилгоо, эмчилгээний заавсрыг боловсруулж батлуулсан байна. | Хэрэгжилтийн хугацаа болоогүй байгаа. | |
| 57. | | | ЭМС-ын 2024 оны 91 дүгээр тушаал | Улаанбурхан өвчний заавсрыг шинэчлэн боловсруулж батлуулсан байна. | - | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/81 дүгээр тушаалаар “Улаанбурхан өвчний эмнэлзүйн заавар”-ыг боловсруулж батлуулсан. | 100 |
| 58. | | | | Зүрхний шигдээсийн эмнэлзүйн заавсрын төслийг боловсруулсан байна. | Зүрхний шигдээсийн эмнэлзүйн заавсрын төслийг хэлэлцүүлж, батлуулж батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/227 дугаар тушаалаар Зүрхний шигдээсийн эмнэлзүйн заавар”-ыг шинэчлэн боловсруулж батлуулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 59. | | | | Зүрхний цочмог дутлын зааврын төслийг боловсруулсан байна. | Зүрхний цочмог дутлын зааврын төсөлд санал авч хэлэлцүүлэн батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/238 дугаар тушаалаар Зүрхний цочмог дутмагшлын оношилгоо, эмчилгээний заавар"-ыг шинээр боловсруулж батлуулсан. | 100 |
| 60. | | | | Ахалази өвчний зааврын төслийг боловсруулсан байна. | Ахалази өвчний зааврын төсөлд санал авч хэлэлцүүлэн батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/237 дүгээр тушаалаар "Ахалази өвчний эмнэлзүйн заавар"-ыг шинээр боловсруулж батлуулсан. | 100 |
| 61. | | | | Целиак өвчний зааврын төслийг боловсруулсан байна. | Целиак өвчний зааврын төсөлд санал авч хэлэлцүүлэн батлуулсан байна. | Целиак өвчний зааврын төслийг боловсруулж, санал авахаар ЭМЯ-ны вэб хуудсанд байршуулсан. | 100 |
| 62. | | | | Кроны өвчний зааврын төслийг боловсруулсан байна. | Кроны өвчний зааврын төсөлд санал авч хэлэлцүүлэн батлуулсан байна. | Кроны өвчний зааврын төслийг боловсруулж, санал авахаар ЭМЯ-ны вэб хуудсанд байршуулсан. | 100 |
| 63. | | | | Нүүрс хүчлийн хийний хордлогын үеийн оношилгоо эмчилгээний зааврын төслийг боловсруулсан байна | Нүүрс хүчлийн хийний хордлогын үеийн оношилгоо эмчилгээний зааврын төсөлд санал авч батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/239 дугаар тушаалаар "Нүүрс хүчлийн хийний хордлогын үеийн оношилгоо эмчилгээний заавар"-ыг шинээр боловсруулж батлуулсан. | 100 |
| 64. | | | - | Умайн лейомиомын зангилааг радио долгионоор түлэх эмчилгээний эмнэлзүйн зааврыг боловсруулж батлуулсан байна. | - | Умайн лейомиомын зангилааг радио долгионоор түлэх оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн зааврын төслийг шинээр боловсруулан батлуулахаар ЭМЯ-ны 8 газрын 6 газраас саналыг аваад байна. | 70 |
| 65. | | | - | Дутуу төрөлтийн эмнэлзүйн зааврын төслийг боловсруулсан байна. | Дутуу төрөлтийн эмнэлзүйн зааврын төслийг хэлэлцүүлж батлуулсан байна. | Дутуу төрөлтийн эмнэлзүйн зааврын төслийг боловсруулсан. | 50 |
| 66. | | | - | Нярайн тархи хөргөх, оношилгоо, эмчилгээний зааврын төслийг боловсруулсан байна. | Зааврын төслийг хэлэлцүүлэх, санал авах үйл ажиллагаа зохион байгуулж батлуулсан байна. | Нярайн тархи хөргөх, гипотермийн эмчилгээний зааврыг боловсруулж Эрүүл мэндийн сайдын А/470 тушаалаар батлуулсан.<br>Нярайн үргэлжилсэн уушгины даралт ихсэлтийн үед азотын исэл эмчилгээ хийх зааврыг Эрүүл мэндийн сайдын А/54 дүгээр тушаалаар батлуулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 67. | | | - | - | Пульсоксиметрээр зүрхний төрөлхийн гажиг оношлох заавар боловсруулж, батлуулсан байна. | Хэрэгжилтийн тайланг гаргах хугацаа болоогүй | |
| 68. | | | - | Нярайн уушгины гипертензийн оношилгоо, эмчилгээний заавр төслийг боловсруулсан байна. | Зааврын төслийг хэлэлцүүлэх, санал авах үйл ажиллагааг зохион байгуулж батлуулсан байна. | . Нярайн үргэлжилсэн уушгины даралт ихсэлтийн үед азотын исэл эмчилгээ хийх заавры Эрүүл мэндийн сайдын А/54 дүгээр тушаалаар батлуулсан. Нярайн уушгины даралт ихсэлтийн үед азотын исэл эмчилгээ хийх сургалтад гадаадад 1, Улаанбаатарт нярайн 16 эмчийг сургасан. 104 нярайд нитрикоксид эмчилгээг 24-72 цагийн хугацаатай хийж амьсгалын аппаратаар удирдсанаар эрчимт эмчилгээний ор хоногийг багасгасан. Өргөө, Амгалан, Хүрээ амаржих газрууд, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-II-ийн нярайн тасгууд Нитрикоксид эмчилгээний аппаратаар бүрэн хангагдсан. | 100 |
| 69. | | | - | Хоол тэжээлийн цочмог дутагдалтай хүүхдийн эмнэлзүйн зааврын төслийг боловсруулсан байна. | Хоол тэжээлийн цочмог дутагдалтай хүүхдийн эмнэлзүйн зааврын төслийг хэлэлцүүлж, батлуулсан байна. | Хоол тэжээлийн цочмог дутагдалтай хүүхдийн эмнэлзүйн зааврын төслийг боловсруулж байна. | 50 |
| 70. | | | - | Зонхилон тохиолдох байрлалын 5 хорт хавдрын оношилгоо, эмчилгээний зааврын төслийг боловсруулсан байна. | Зонхилон тохиолдох байрлалын 5 хорт хавдрын оношилгоо, эмчилгээний зааврын төсөлд санал авч батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/351, А/352, А/353, А/354, А/355 дугаар тушаалаар байгуулсан дэд ажлын хэсгүүд зонхилон тохиолдох байрлалын буюу ходоодны хорт хавдар, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар, элэгний хорт хавдар, хөхний хортой хавдрын заавар, хөхний хоргүй хавдрын заавар, бай эмчилгээний зааврын төслийг боловсруулсан. Холбогдох зөвлөлүүдэд хэлэлцүүлэхэд бэлдэж байна. | 50 |
| 71. | | | - | Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний зааврын төслийг боловсруулсан байна. | Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний зааврын төсөлд санал авч батлуулсан байна | Зааврын төслийг боловсруулсан. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| АНАГААХ УХААНЫ ИННОВАЦИ, ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЛААРХ БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТИЙН НЭГДСЭН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТ | | | | | | | |
| 72. | *ЗГҮАХХАХТ 2.3.2.6.416* Хиймэл оюун ухааныг эрүүл мэндийн салбарт ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах | Батлагдсан журам Сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо | Ажлын хэсэг байгуулагдсан | Журмын төслийг боловсруулж, яамны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан байна. | Эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургалтад хамруулсан байна. | Эрүүл мэндийн салбарт хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоонд ашиглах журмыг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн "Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай" А/491 дүгээр тушаалаар батлуулсан.<br>Хиймэл оюун ухааны хэрэглээ харьцангуй шинэ технологи тул ажлын хэсгийн гишүүдийг мэдээллээр хангах ажлыг эрчимтэй хийсэн. Тухайлбал: ДЭМБ-аас 2023 онд боловсруулж хэвлүүлсэн "Regulatory considerations on artificial intelligence for health" гэсэн 80 хуудастай номыг орчуулж, ажлын хэсгийн гишүүдийн ажлын хүрээнд ашиглаж байна.<br>Мөн ЦХИХХЯ-наас зохион байгуулсан "Хиймэл оюун ухааны бэлэн байдлын үнэлгээ" сэдэвт хэлэлцүүлэгт ажлын хэсгийн гишүүдийг оролцуулсан.<br>Мөн ЦХИХХЯ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран зохион байгуулсан "Data+Ai Conference" буюу Их өгөгдөл+хиймэд оюун ухааны чуулга уулзалтад ажлын хэсгийн гишүүдийг оролцуулсан.<br>Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нийт 4 удаа (танхимаар 2 удаа, онлайнаар 2 удаа) хуралдуулсан.<br>Хиймэл оюун ухааныг эрүүл мэндийн салбарт ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх баримт материалуудын (журмын төсөл, +хэд хэдэн тушаалын төсөл) төслийг боловсруулсан. | 70 |
| 73. | Эрүүл мэндийн салбарт 2025-2029 онд шинжлэх ухаан, технологийг | Батлагдсан тушаал | | Эрүүл мэндийн салбарт 2025-2029 онд шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийн | Эрүүл мэндийн салбарын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг Шинжлэх | Эрүүл мэндийн салбарын шинжлэх ухаан, технологийг 2025-2029 онд хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтыг тодорхойлох санал асуулга бүхий албан бичгийг | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг шинэчлэн боловсруулах | | | төслийг боловсруулсан байна. | ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж тушаалаар батлуулсан байна | холбогдох байгууллагуудад 2024 оны 11 дүгээр сард хүргүүлж, хариуг албан бичгээр авсан.<br>Эрүүл мэндийн салбарын шинжлэх ухаан, технологийг 2025-2029 онд хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсэгт зөвлөгөө дэмжлэг үзүүлэх шинжээчдийн багийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ажлын удирдамжийг боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/178 дугаар тушаалаар батлуулсан.<br>2020-2025 оны хугацаанд Шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлсэн, хэрэгжүүлж дууссан, шинээр эхлүүлсэн улсын захиалгат, цөм технологийн төсөл, эрүүл мэндийн чиглэлийн суурь судалгааны төслийн чиглэл, үр дүнгийн даалгаврын хэрэгжилтэд үнэлгээг хийж байна.<br>Ажлын хэсгийн гишүүдийн телеграм группыг байгуулж, гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангах, мэдээлэл солилцоог хэрэгжүүлж байна.<br>Ажлын хэсгийн гишүүдийн хурлыг 05 дугаар сард онлайн байдлаар зохион байгуулсан ба ажлын хэсгийн гишүүдэд яамны харьяа байгууллагууд, эрүүл мэндийн эрдэм шинжилгээний байгууллагуудаас ирүүлсэн Эрүүл мэндийн салбарын шинжлэх ухаан, технологийг 2025-2029 онд хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтыг тодорхойлох саналуудыг хүргүүлж, нэгтгэл, эрэмбийг хийж байна. | |
| 74. | *МУХТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-2.3.2.6.415 МУХТ 3.1.2.1* | Батлагдсан журам | | Зохицуулалтын журам батлагдсан байна. | - | Журмын төслийг боловсруулсан. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Алсын зайн анагаах ухаан телемедицинийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ашиглах боломжийг өргөжүүлэх | Тоон мэдээлэл | | | | | |
| 75. | Эрүүл мэндийн технологийн үнэлгээ хийх журам, аргачлал боловсруулах | Батлагдсан тушаал | - | Журам, аргачлалын төслийг боловсруулж, яамны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна. | Журам, аргачлалын төслийг хэлэлцүүлж, санал авч батлуулсан байна. | Эрүүл мэндийн технологийн үнэлгээ хийх журам, аргачлалын төслийг АХБ-ны зөвлөхүүдээр боловсруулаад байна. Төсөлд ЭМДЕГ, ЭЭХХЗ, мэргэжлийн салбар зөвлөл, холбогдох мэргэжлийн нийгэмлэг холбоодоос санал авахаар ажиллаж байна.<br>ЭМДЕГ, ЭЭХХЗГ, ЭМХТ-ийн технологийн үнэлгээний хэлэлцүүлэн сургалтад тус бүр 30, 30 мэргэжилтнүүдийг суулгасан. Уг мэргэжилтнүүдээс ажлын хэсгийг байгуулахаар тушаалын төслийн эхний байдлаар боловсруулаад байна.<br>Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл (3843-MON, 3844-MON, 0672-MON) Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх бүрэлдэхүүн хэсэг Эрүүл мэндийн технологийн үнэлгээний арга хэрэгслийг тусламж, үйлчилгээний багц боловсруулахад ашиглах удирдамжийн үндсэн агуулга, эмнэлзүйн үр дүнтэй байдлыг үнэлэх удирдамжийн төслийг АХБ-ны зөвлөхүүдээр боловсруулаад байна. | 50 |
| 76. | *Эрүүл мэндийн тухай хуулийн 37.1 дэх хэсэг*<br>Анагаах ухааны салбарт оношилгоо, | Батлагдсан журам | - | Журмын төслийг боловсруулж, яамны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан байна. | - | Анагаах ухааны салбарт оношлогоо, эмчилгээний шинэ арга турших, нэвтрүүлэх, бүртгэх, баталгаажуулах, мэдээлэх журмын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсэгт зөвлөгөө | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эмчилгээний шинэ арга турших, нэвтрүүлэх, бүртгэх, баталгаажуулах, мэдээлэх журам боловсруулах | | | | | дэмжлэг үзүүлэх шинжээчдийн багийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн "Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай" А/11 дүгээр тушаалаар батлуулсан.<br>Ажлын хэсгийн гишүүдийн телеграм группыг үүсгэж, мэдээлэл солилцооны боломжийг хангасан.<br>Ажлын хэсгийн ээлжит хурлыг 04 дүгээр сарын 18-ны өдөр хуралдуулсан.<br>"Анагаах ухааны салбарт оношилгоо, эмчилгээний шинэ аргыг бүртгэх, баталгаажуулах, мэдэ элэл журам"-ын төслийн хувилбарыг боловсруулж, ажлын хэсгийн гишүүдэд тараасан ба саналуудыг нэгтгэж байна. | |
| 77. | *ЗГҮАХ 2.1.4.3.291*<br>Анхан шатны спортын сургалт, дасгалжуулалтын үр дүнг сайжруулж, спортын шинжлэх ухаан, спортын анагаах ухааны тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Шинээр нэвтрүүлсэн технологийн тоо | 2024 онд спортын гэмтлийн төв байгуулагдсан | - | Спортын гэмтэлд үзүүлэх тусламж, үйлчилгээнд шинэ технологийг нэвтрүүлсэн байна. | Гэмтэл согог судлалын үндэсний төвд шинээр байгуулагдсан "Спортын гэмтлийн төв" спортын гэмтлийн тусламж, үйлчилгээнд дараах шинэ технологийг нэвтрүүлсэн.<br>1. Ясны блокийн тусламжтайгаар мөрний үений тогтворгүйтэхийг жижиг зүслэгээр эмчлэх мэс заслыг 10 үйлчлүүлэгчид хийж эмнэлзүйн нэвтрүүлсэн.<br>2. Шагайн үений тогтворгүйтэхийг дурангийн мэс заслын аргаар эмчлэх мэс заслыг хийж эхэлсэн.<br>Дурангийн аргаар хиймэл арьсны тусламжтайгаар мөрний капсулитыг эмчлэх мэс заслыг хийж эхэлсэн. | 100 |
| **ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТИЙН НЭГДСЭН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ** | | | | | | | |
| 78. | Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам болон шалгуур | Батлагдсан журам, шалгуур | - | Журам, шалгуурыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулах, | Журам, жагсаалтын төсөлд санал авч батлуулсан байна. | Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд 12 удаагийн хурлыг зохион байгуулж 157 эрүүл мэндийн | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үзүүлэлтийг шинэчлэх | | | төслийг боловсруулсан байна. | | байгууллагын асуудлыг хэлэлцэж, 131 байгууллагад магадлан итгэмжлэл олгох тухай Эрүүл мэндийн сайдын 11 ширхэг тушаал батлуулсан.<br>Магадлан итгэмжлэлийн шалгуур боловсруулах ажлын хэсгийн тушаалын төслийг боловсруулан, санал авахад бэлэн болгосон. | |
| 79. | Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам, шалгуур үзүүлэлтийг боловсруулах | Батлагдсан журам, шалгуур | - | Журам, шалгуурыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулах, төслийг боловсруулсан байна. | Журам, жагсаалтын төсөлд санал авч батлуулсан байна. | Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 16,17 дугаар хэсэгт заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зөвшөөрөл олгох холбогдох журмыг нягтлан Захиргааны ерөнхий хуулийн 65 дугаар зүйлд заасны дагуу улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүй журмыг хүчингүй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлж, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох зохицуулгатай холбоотой тушаалыг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн А/40 дугаар тушаалаар хүчингүй болгосон.<br>Үүнтэй холбогдуулан эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Зөвшөөрлийн тухай хууль болон салбарын бусад хууль, журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах болон журмыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг ЭМС-ын 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/82 дугаар тушаалаар батлагдсан. Тус ажлын хэсэг нийт 6 удаа хурал, хэлэлцүүлэг хийж ЗГХЭГ-т 2025 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 1а/1074 дугаар, 4 дүгээр сарын 11-ний өдрийн 1а/1802 дугаар, 6 дугаар сарын 10-ны өдрийн 1а/3053 дугаар албан бичгээр Зөвшөөрлийн тухай хуульд | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөлд саналыг хүргүүлсэн. | |
| ГАДААД ОРОНД ИЛГЭЭХ ИРГЭДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТИЙН НЭГДСЭН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТ | | | | | | | |
| 80. | Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэх | Батлагдсан тушаал | ЭМС-ын …… тушаал | - | Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн боловсруулж батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/91 дүгээр тушаалаар зарим мэргэжлийн салбар зөвлөлийг шинэчлэн байгуулсан. | 100 |
| 81. | *ЗГҮАХХАХТ 2.3.2.4.413* Гадаад улс оронтой хамтран ажиллах гэрээ байгуулан тусламж, үйлчилгээ үзүүлэх боломж бүрдүүлэх | Гэрээ байгуулсан орны тоо Судалгаа, гэрээний гүйцэтгэлийн хувь | | Гадаад улсын эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулах бэлтгэл ажил хангагдсан байна. | Гадаад улсын 3 эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан байна. Судалгаа гэрээ байгуулах ажлын гүйцэтгэл 50 хувьтай байна. | Монгол Улсын иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг чанартай, чирэгдэлгүй, хөнгөлөлттэй үнээр үзүүлэх чиглэлээр БНЭУ-ын Global Care, БНТУ-ын УШАС, Гүвэн , Ажибадам, Коч, Медикана, Медикал парк эмнэлгүүдтэй санамж бичиг байгуулаад байна. Цаашид Монгол Улсын иргэд тус эмнэлгүүдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авахад хөнгөлөлт үзүүлэх 2 талын гэрээ байгуулна. | 100 |
| 82. | *ЗГҮАХХАХТ 2.3.4.1.446* Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэн, тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт | Гадаад улсад эмчилгээнд илгээж байгаа өвчлөлөөс бууруулсан тоо | 25 | - | Монгол улсад оношлогдож эмчлэгдэх боломжгүй 5 өвчний технологийг эх орондоо нэвтрүүлсэн байна. | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх зорилгоор 13 багийг гадаад улсад суралцуулсан бөгөөд одоогоор 8 багийн сургалт бүрэн дуусаж, шийдвэрлэсэн. 2025 оны 6 дугаар сарын байдлаар дээрх 13 багаас 8 багийн сургалт бүрэн дууссан. сургалтад хамрагдсан 4 баг эмнэлгийн тусламж, үйлчилгээндээ сурсан технологио ашиглаж эхлээд байна. эдгээр шинээр нэвтэрсэн 4 технологиос 3 эмчилгээний арга зайлшгүй шаардлагаар гадаад улсад илгээдэг эмчилгээнд байсан.Тодруулбал, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | технологи нэвтрүүлэн, тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | | | | | 1. УГТЭ-ийн "Гол судасны хүнд хэлбэрийн цүлхэн хуулралын мэс заслын баг" цээжний гол судасны цүлхэн болон зүрхний бусад эмгэгийн үед цусны зохиомол эргэлтийн технологи ашиглан хиймэл судсаар солих мэс засал, гол судасны нумыг хиймэл судсаар солих мэс заслыг бусад зүрхний нээлттэй мэс заслуудтай хавсран гүйцэтгэх технологуудыг өөрийн эх орондоо нутагшуулах ажлын амжилттай эхлүүлж, гол судасны хүнд хэлбэрийн цүлхэн хуулрал оноштой 8 үйлчлүүлэгчид амжилттай мэс засал хийсэн.<br>2. УГТЭ-ийн "Тархины гүний байрлалтай хавдрын мэс заслын баг" гадаад сургалтад хамрагдан ирээд тархины ховдлын байрлалтай хавдар 5, таламус болон суурийн зангилааны хавдар 7, өнчин тархины (гипофизийн) хавдар 6, тархины гүний бүтцэд байрласан хавдрын нийт 18 тохиолдолд мэс заслыг амжилттай хийсэн.<br>3. УХТЭ-ийн "Зүрхний титэм судасны хүнд хэлбэрийн нарийсал, судасны дисплази эмчилгээний баг"-ууд гадаад сургалтад хамрагдан ирж шинэ технологийг амжилттай нэвтрүүлээд байна.<br>4. СЭМҮТ-ийн аутимзмын хүрээний оношилгоо, эмчилгээний баг "ADOS-2" аутизмын оношилгооны аргыг нэвтрүүлээд байна. | |
| 83. | *ЗГҮАХХАХТ 2.3.4.1.447*<br>Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаад улсад урт богино хугацааны | Суралцсан багийн тоо | 12 | Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаад улсад урт богино хугацааны сургалтад багаар хамруулах бэлтгэл ажлыг хангасан байна. | Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаад улсад урт богино хугацааны сургалтад багаар хамруулсан байна. | Эрүүл мэндийн салбарт шинээр нэвтрүүлэх шаардлагатай технологын төслийг хэлэлцэн шийдвэрлэн<br>2025 оны 6 дугаар сарын байдлаар шинэ технологи нэвтрүүлэх 8 багийн сургалт бүрэн дуусаад байна. Тодруулбал, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалтад багаар хамруулах | | | | | 1. ЭНЭҮТ II -ийн "Хүүхдийн зүрхний хэм алдагдлын үеийн электрофизиологийн оношилгоо, эмчилгээ" баг 5 эмч, мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр БНЭУ- Сарвадоя эмнэлэгт 1 сар<br>2. УХТЭ-ийн "Зүрхний титэм судасны хүнд хэлбэрийн нарийсал, судасны дисплази эмчилгээний баг" 5 эмч, мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр БНХАУ-ын Ида эмнэлэгт 2 сар<br>3. ГССҮТ-ийн "Дээд болон доод мөчдийн төрөлхийн хүнд хэлбэрийн дутуу хөгжил, гэмтлийн мэс засал" баг 2 эмчийн бүрэлдэхүүнтэйгээр БНХАУ-ын Сужоу их сургуулийн эмнэлэгт 3 сар<br>4. УГТЭ-ийн "Тархины гүний байрлалтай хавдрын мэс заслын баг" 3 эмч, мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр БНТУ-ын Чок их сургуулийн эмнэлэг, Американ эмнэлэгт 2 сар<br>5. УГТЭ-ийн "Гол судасны хүнд хэлбэрийн цүлхэн хуулралын мэс заслын баг" 4 эмч, мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр БНСУ-ын Йонсей их сургуулийн Северанс эмнэлэгт 1 сар<br>6. ХСҮТ-ийн "Нейронавигацийн систем, нейромониторийг ашиглан тархины гүний төвөгтэй байрлалтай, гавлын суурийн хэсгийн хавдрын мэс засал эмчилгээ" баг 5 эмч, мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр БНХАУ-ын Чанжоугийн Ардын Эмнэлэгт 3 сар<br>7. ХСҮТ-ийн "Толгой хүзүүний өргөтгөсөн мэс заслын дараах согог, эрхтнийг хиймэл эрхтэн буюу протезоор орлуулах (хиймэл төвөнх), нармайн хавдрын мэс заслын эмчилгээ" баг 4 эмч, мэргэжилтний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүрэлдэхүүнтэйгээр АНУ-ын Langone Health Center-т 1 сар<br>8. СЭМҮТ-ийн "Аутизмын хүрээний эмгэгийн оношилгоо, эмчилгээ" баг 5 эмч, мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр БНТУ-ын Кануни их сургуулийн эмнэлэгт 1 сар суралцсан. | |
| 84. | Гадаадын ур чадвартай мэргэжилтний урьж ажиллуулах үйл ажиллагааг зохион байгуулах | Урьж ажиллуулсан мэргэжилтний тоо | - | Гадаадын ур чадвартай мэргэжилтнийг урьж ажиллуулах судалгаа, бэлтгэл ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулсан байна. | Гадаадын ур чадвартай мэргэжилтнийг урьж ажиллуулсан байна. | 1. Эрүүл мэндийн яамны Шинжлэх ухаан,технологийн зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн хурлаар Эрүүл<br>мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх эрүүл мэндийн тусламж,үйлчилгээнд 2024-2025 онд хэрэгжих орчин үеийн дэвшилтэт технологи шинээр<br>нэвтрүүлэх 15 төсөл, арга хэмжээ шалгарснаас Үндэсний 13 багийг гадаад улсадсуралцуулахаар шийдвэрлэсэн. 2025 оны 6 дугаар сарын байдлаар дээрх 13 багаас<br>8 багийн сургалт бүрэн дууссан. Үүнд:<br>-ЭНЭҮТ II -ийн "Хүүхдийн зүрхний хэм алдагдлын үеийн электрофизиологийн оношилгоо, эмчилгээ" баг 5 эмч, мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр БНЭУ- Сарвадояэмнэлэгт 1 сар<br>-<br>УХТЭ-ийн "Зүрхний титэм судасны хүнд хэлбэрийн нарийсал,судасны дисплази эмчилгээний баг" 5<br>эмч, мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр БНХАУ-ын Ида эмнэлэгт 2 сар<br>-ГССҮТ-ийн "Дээд болон доод мөчдийн төрөлхийн хүнд хэлбэрийн дутуу<br>хөгжил, гэмтлийн мэс засал" баг 2 эмчийн бүрэлдэхүүнтэйгээр БНХАУ-ын Сужоу ихсургуулийн эмнэлэгт 3 сар<br>- УГТЭ-ийн "Тархины гүний<br>байрлалтай хавдрын мэс заслын баг" 3 эмч, мэргэжилтний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүрэлдэхүүнтэйгээрБНТУ-ын Чок их сургуулийн эмнэлэг, Американ эмнэлэгт 2 сар<br>- УГТЭ-ийн "Гол судасны хүнд хэлбэрийн цүлхэн хуулралын мэс заслын баг" 4 эмч, мэргэжилтнийбүрэлдэхүүнтэйгээр БНСУ-ын Йонсей их сургуулийн Северанс эмнэлэгт 1 сар<br>- ХСҮТ-ийн "Нейронавигацийн систем, нейромониторийг ашиглан тархины гүний төвөгтэй байрлалтай, гавлын суурийнхэсгийн хавдрын мэс засал эмчилгээ" баг 5 эмч, мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр БНХАУ-ын<br>Чанжоугийн Ардын Эмнэлэгт 3 сар<br>- ХСҮТ-ийн "Толгой хүзүүний өргөтгөсөнмэс заслын дараах согог, эрхтнийг хиймэл эрхтэн буюу протезоор орлуулах (хиймэл<br>төвөнх), нармайн хавдрын мэс заслын эмчилгээ" баг 4 эмч, мэргэжилтнийбүрэлдэхүүнтэйгээр АНУ-ын Langone Health Center-т 1 сар<br>- СЭМҮТ-ийн "Аутизмын хүрээний эмгэгийн оношилгоо, эмчилгээ" баг 5 эмч, мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээрБНТУ-ын Кануни их сургуулийн эмнэлэгт 1 сар суралцсан.<br>ЭХЭМҮТ-ийн "Хүүхдийн хавсарсан хөх, хүнд<br>хэлбэрийн зүрхний төрөлхийн гажигийн үеийн мэс засал эмчилгээ", ГССҮТ-ийн "Хүзүү,сээр, бүсэлхий нурууны төрөлхийн хүнд хэлбэрийн мурийлт эмгэгийн мэс засал"<br>багуудын сургалт үргэлжилж байна.<br><br>- ЭХЭМҮТ-ийн "Үр хөврөлийгумайд суулгахаас өмнө генетикийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оношилгоо", ГССҮТ-ийн "Доод мөчдийн төрөлхийн хүнд хэлбэрийн согогууд, гэмтлийн дараах шагайн үений тогтворгүйтэлийн үеийн мэс заслынэмчилгээ, доод мөчдийн дутуу хөгжил ясны хавдрын нөхөн сэргээх мэс засал" багуудын сургалт хойшлогдож, УНТЭ-ийн "Меньерийнөвчний хүнд хэлбэрийн үеийн мэс засал эмчилгээ"-ний багийн сургалт цуцлагдсан.<br>багийн сургалт цуцлагдсан.<br>2.<br>УГТЭ-ийн "Голсудасны хүнд хэлбэрийн цүлхэн хуулралын мэс заслын баг" цээжний гол судасны цүлхэн болон зүрхний бусад эмгэгийн үед цусны зохиомол эргэлтийн технологиашиглан хиймэл судсаар солих мэс засал, гол судасны нумыг хиймэл судсаар солих мэс заслыг бусад зүрхний нээлттэй мэс заслуудтай хавсран гүйцэтгэхтехнологуудыг өөрийн эх орондоо нутагшуулах ажлын амжилттай эхлүүлж байна. Гол судасны хүнд хэлбэрийн цүлхэн хуулрал оноштой 8 үйлчлүүлэгчид амжилттай мэсзасал хийсэн.<br>3. УГТЭ-ийн "Тархины гүний байрлалтай хавдрын мэс заслын баг" гадаад сургалтад хамрагдан ирээд тархины ховдлынбайрлалтай хавдар 5, таламус болон суурийн зангилааны хавдар 7, өнчин тархины (гипофизийн) хавдар 6 тохиолдол, тархины гүний бүтцэд байрласан хавдрын нийт 18тохиолдолд тус тус мэс заслыг амжилттай хийсэн. | |